



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/254

Хэрлэн сум

Техникийн нөхцөлийн хураамж төлөхөд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид 2022 онд Хэнтий аймагт хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын техникийн нөхцөлийн хураамж төлөхөд 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 25-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Төлбөр төлөгдөөгүй техникийн нөхцлийн жагсаалт

д/д	Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд	Зориулалт	Техникийн нөхцөлийн дугаар	Мөнгөн дүн /төгрөг/
1	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	Дулаан дамжуулах төв	ХЭ 22/36	330,000.00
2	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн хичээлийн байр	ХЭ 22/38	330,000.00
3	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	Төв цэнгэлдэх хүрээлэн	ХЭ 22/40	330,000.00
4	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	127 айлын жишиг хороололын цахилгаан хангамжийн ажил	ХЭ 22/41	330,000.00